



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.25. № 386
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГА Ч.БАТСАЙХАН ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Агаарын чанарын албаны удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ

E:\2015 on\Yavsan bichig\2015.03.26.NAgaarChGazart..Gerchilgee.docx

1110400386



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Т.Сарантуяа

Нийслэлийн аудитын
газрын дэд дарга
өрөөний утас: 327734

Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын
менежер
өрөөний утас: 315558

В.Эрдэнэцогт

Багийн ахлах аудитор

Д.Нарантуяа

Аудитор

ТАБ-ын хаяг: Нийслэлийн
аудитын газар

Байршил: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг.

Ж.Лхагвасүрэнгийн гудамж.

Нийслэлийн засаг
захиргааны V байр

E mail: ub@audit.mn

Вэб: www.city.audit.mn

Аудитын тайлан

Агуулга

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль. эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго. үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт. аудитын арга зүй. хэрэгжүүлсэн горим. хяналтын сорил болон нарийвчилсан горим. түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого. зардлын гүйцэтгэл. түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд. түүний үр дагавар
8. Гол. онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд. тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-АХ/2015/-СА-II-4-26/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Агаарын чанарын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 2 дугаар сарын 25-наас 2015 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын СА-ын II албаны IY багийн ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитор Д.Нарантуяа нар 2015 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 2 дугаар сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 25-нд Нийслэлийн Агаарын чанарын албаны удирдлагад хүргүүлэв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн Агаарын чанарын албаны төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант

онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй, түүнд нийцүүлэн гарсан зарим журам, зааварт өөрчлөлт орсон байна. Үүнд МУ-ын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Нийслэлийн Агаарын чанарын алба нь “агаарын чанарыг тодорхойлох, агаарын бохирдолд хяналт шинжилгээ судалгаа хийх, бохирдуулагч эх үүсвэрүүдээс байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэр, Улаанбаатар хотод хэрэгжүүлэх чиг үүрэгтэй” ажиллаж байна.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Нийслэлийн Агаарын чанарын албаны дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны төсвийг Нийслэлийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн Агаарын чанарын албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нийслэлийн Агаарын чанарын албаны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Нийслэлийн Агаарын чанарын албаны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Агаарын чанарын албаны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Агаарын чанарын албаны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Нийслэлийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Агаарын чанарын албаны төсвийн захирагч нь 2014 онд нийслэлийн төсвөөс урсгал зардалд 435,694.1 мянга, хөрөнгө оруулалтын 662,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого батлагдсан байна. Нэмэлт санхүүжилтээр Засаг даргын нөөц хөрөнгөөс 23,262.0 мянга, урд оны төсвийн хэмнэлт 4,447.1 мянга, Цэвэр агаар сангаас 20,022.1 мянга, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 5,576.1 мянган төгрөгийн орлого орсон байна. Хөрөнгө оруулалтын ажлын 147,844.2 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, урд оны авлага 7,384.0 мянган төгрөгийн орлого орсоноос гадна үртсэн, шахмал түлшний үйлдвэрт олгох санхүүгийн дэмжлэг 439,017.6 мянга төгрөгийг байгууллагын дансаар дамжигдан “Үртсэн, шахмал түлшний үйлдвэр” НӨҮГ-ын дансанд шилжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 435,694.1 мянган төгрөг зарцуулахаас 411,149.0 мянган төгрөг зарцуулж, санхүүжилтийн үлдэгдэл 24,545.1 мянга, эхний үлдэгдэл 1.0 мянга, өөрийн орлого 5,576.1 мянга нийт 30,122.2 мянган төгрөгийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлжээ.

Хөрөнгө оруулалтын 662,000.0 мянган төгрөгийн ажил бүрэн хийгдэж барьцаа хөрөнгө 5 хувь буюу 33,100.0 мянган төгрөгийг барьцаа дансанд байршуулахаас 8,100.0 мянган төгрөгийг байгууллагын барьцаа дансанд байршуулж, 25,000.0 мянган төгрөгийн барьцааны мөнгийг арилжааны банкны батлан даалтаар урьдчилж гүйцэтгэгч компанид шилжүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны батлагдсан төсвийн хуваарь. 1 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны нэгдсэн системд байршуулсан ба 5,000.0 мянган төгрөгөөс дээш худалдан авалтын ажил гүйлгээ гараагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчих, ажил гүйлгээ зөрүүтэй бүртгэгдэх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй юм.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийслэлийн Агаарын чанарын албаны төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 656,154.2 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материал, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорилд нийт нэмэгдсэн бараа материал, үндсэн хөрөнгийн 57,4 хувь, нийт зардлын 42,6 хувийг хамруулав.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах алдаа илэрсэн байна.Үүнд:

1.Тус байгууллагын дансаар 439,017.3 мянган төгрөгийн үртсэн, шахмал, түлшний үйлдвэрт олгох санхүүгийн дэмжлэг дамжин хэрэгжсэнийг үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлого, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1." аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх" заалтыг зөрчсөн.

- Шийдвэрлэсэн: Дээрх 439,017.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитаар залруулсан ба зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах талаар байгууллагын удирдлага хариу ирүүлсэн.

2.Тээвэр шатахууны зардлыг 619.1 мянган төгрөгөөр илүү, бичиг хэргийн зардлыг 522.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” –ын 3.2 “хүлээн зөвшөөрөх ба үнэлэх”, 3.5 “төсвийн зардлыг одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ” заалттай нийцэхгүй байна.

- Шийдвэрлэсэн: Дээрх 619.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитаар залруулсан ба зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах талаар байгууллагын удирдлага хариу ирүүлсэн.

3. Кассын нярав 3,669.0 мянган төгрөгийн жижиг мөнгөн сангийн тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар баталсан Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан" Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.9 " мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн гүйлгээ хийнэ.", 5.4" төсвийн байгууллага жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайлан мэдээг үнэн зөв тогтоосон цаг хугацаанд тайлагнах...."заалтыг зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн: Жижиг мөнгөн сангийн тайланг цаг хугацаанд нь гаргаж байх зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн хариу ирүүллээ.

4. Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын орлого 4,372.0 мянган төгрөгийг Цэвэр агаарын санд төвлөрүүлэлгүй, Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-342 тоот “Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ тогтоох тухай” тушаалын 2.” Дээрхи үйлчилгээний хөлс, хураамжаас орсон орлогыг Цэвэр агаарын санд төвлөрүүлэхийг ...” заалтыг зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн: Агаарын чанарын хяналт шинжилгээний орлогыг Цэвэр агаарын санд төвлөрүүлж байх зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн хариу ирүүллээ.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Хууль тогтоомж, заавар журам зөрчсөн 8,041.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ болон үндсэн хөрөнгө, бараа материалд биет тест хэрэгжүүлээгүй тул завсрын аудитаар хамруулах болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 447,677.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 439,636.4 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэж, 8,041.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газар аудит хийж аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Агаарын чанарын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАРАНТУЯА

2015.03.24



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Мөнгөн хөрөнгө.....

Асуудал 2
Орлого

2010оны 3 дугаар сарын01

2015 оны 3 дугаар сар 19

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн Агаарын чанарын албаны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Агаарын чанарын албаны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Санхүүгийн тайлан

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Тус байгууллагын дансаар 439,017.3 мянган төгрөгийн үртсэн, шахмал, түлшний үйлдвэрт олгох санхүүгийн дэмжлэг дамжин хэрэгжсэнийг үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлого, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1. "аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх" заалтыг зөрчсөн.

Мөн тээвэр шатахууны зардлыг 619.1 мянган төгрөгөөр илүү, бичиг хэргийн зардлыг 522.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" –ын 3.2 "хүлээн зөвшөөрөх ба үнэлэх", 3.5 "төсвийн зардлыг одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ" заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд орлого, зардал буруу илэрхийлэгдэх

НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Үр дүнгийн тайланд залруулга хийх

Үр дүнгийн тайланд залруулга хийх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2

НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Мөнгөн кассын нярав 3,669.0 мянган төгрөгийн жижиг мөнгөн сангийн тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар баталсан Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.9 "мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн гүйлгээ хийнэ.", 5.4 "төсвийн байгууллага жижиг мөнгөн

НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Жижиг мөнгөн сангийн тайланг цаг хугацаанд нь гаргаж байх

сангийн зарцуулалтын тайлан мэдээг үнэн
зөв тогтоосон цаг хугацаанд
тайлагнах..."заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Бэлэн мөнгөний орлого, зарлага буруу
илэрхийлэгдэх, мөнгөн хөрөнгө шамшигдах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа
илэрхийлсэн.

Асуудал 2: Орлого

Тэргүүлэх ач холбогдол №2

НАГ-ын ажиглалт

Агаарын чанарын хяналт шинжилгээний
ажлын хөлсийг 4,372.0 мянган төгрөгийг
Цэвэр агаарын санд төвлөрүүлэлгүй,
Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн нь
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2011 оны А-342 тоот "Агаарын чанарын
хяналт шинжилгээний ажлын
үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ
тогтоох тухай" тушаалын 2." Дээрхи
үйлчилгээний хөлс, хураамжаас орсон
орлогыг Цэвэр агаарын санд
төвлөрүүлэхийг ..." заалтыг зөрчсөн
байна.

НАГ-ын зөвлөмж

Агаарын чанарын хяналт шинжилгээний
орлогыг Цэвэр агаарын санд төвлөрүүлж
байх

Эрсдэлүүд

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг
нийслэлийн төсөвт төвлөрүүлсэнээр өглөг
үүсэх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа
илэрхийлсэн.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

2015.03.19

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

2015.03.19

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАРАНТУЯА

2015.03.18

Байгууллагаас ирүүлсэн хариу

Т. Сарантулааг
23/III



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АГААРЫН ЧАНАРЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хангарьд ордон, Бага тойруу 3, Ц.Жигжиджавын гудамж 9
Утас: 31-48-76, Факс: (976-11) 32-46-32
E-mail: info@airquality.ub.gov.mn

2016.03.23 № 01/83
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсний дагуу менежментийн захидалтай танилцлаа. Бичиг хэрэг болон тээвэр шатахууны зардлыг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын зардал хооронд шилжүүлж зарцуулсан болно. Цаашид санхүүгийн аудитаар өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА  Ч.БАТСАЙХАН



1150-2014-A52014-A5
2016.03.23

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НИЙТ ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	228,355,961.61	194,419,235.60
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,000.01	8,100,000.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	0.01	8,100,000.00
Төгрөг	0.01	8,100,000.00
Орон нутгийн харилцах	0.01	8,100,000.00
БАРАА МАТЕРИАЛ	211,532,596.60	186,319,235.60
Хангамжийн материал	211,532,596.60	186,319,235.60
Бичиг хэргийн материал	1,115,350.00	1,014,998.00
Аж ахуйн материал	1,592,594.00	1,029,592.00
Сэлбэг хэрэгсэл	151,674,100.60	126,320,920.60
Түлш, шатах тослох материал	1,400,000.00	875,000.00
Бусад (хуучин: Бусад хангамжийн материал)	55,750,552.00	57,078,725.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	228,355,961.61	194,419,235.60
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	678,633,495.37	1,035,135,565.35
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	678,633,495.37	1,035,135,565.35
Биет хөрөнгө	671,075,894.62	1,032,183,898.56
Авто-тээврийн хэрэгсэл	40,689,319.82	181,445,000.04
Авто-тээврийн хэрэгсэл - Анхны өртөг	147,523,120.00	290,965,920.00
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(106,833,800.18)	(109,520,919.96)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	606,852,081.08	828,829,925.35
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	1,338,106,274.00	1,828,894,561.00
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(731,254,192.92)	(1,000,064,635.65)
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,522,627.16	17,189,746.65
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	24,574,140.00	28,762,140.00
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(9,051,512.84)	(11,572,393.35)
Бусад үндсэн хөрөнгө	8,011,866.56	4,719,226.52
Бусад үндсэн хөрөнгө	22,392,200.00	16,463,200.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(14,380,333.44)	(11,743,973.48)
Биет бус хөрөнгө	7,557,600.75	2,951,666.79
Програм хангамж	6,321,666.75	2,951,666.79
Програм хангамж - Анхны өртөг	19,920,500.00	14,030,000.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(13,598,833.25)	(11,078,333.21)

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	678,633,495.37	1,035,135,565.35
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	906,989,456.98	1,229,554,800.95
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,821,084.00	8,428,200.00
Өглөг	7,821,084.00	8,428,200.00
Бусад өглөг	7,384,000.00	8,428,200.00
Байгууллагад төлөх өглөг	7,384,000.00	8,428,200.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,821,084.00	8,428,200.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,821,084.00	8,428,200.00
Засгийн газрын сан	924,598,017.41	924,598,017.41
Хуримтлагдсан үр дүн	(25,429,644.43)	296,528,583.54
Өмнөх үеийн үр дүн	(25,429,644.43)	(25,429,644.43)
Тайлант үеийн үр дүн	-	321,958,227.97
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	899,168,372.98	1,221,126,600.95
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	906,989,456.98	1,229,554,800.95

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,123,524,328.00	1,120,956,100.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	2,123,524,328.00	1,120,956,100.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	1,959,141,065.00	1,120,956,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	845,344,000.00	435,694,100.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	19,980,000.00	23,262,000.00
Хөрөнгийн	1,093,817,065.00	662,000,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,108,083,203.43	174,192,520.27
Бараа, үйлчилгээний борлуулалт	1,108,083,203.43	174,192,520.27
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	1,108,083,203.43	174,192,520.27
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	528,662,316.83	169,745,450.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	4,447,070.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,231,607,531.43	1,295,148,620.27
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	202,652,433.00	201,627,555.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	181,389,114.00	180,364,588.00
Үндсэн цалин	146,066,286.00	138,714,733.00
Бусад нэмэгдлүүд	13,101,322.00	20,409,790.00
Бусад нэмэгдэл	13,101,322.00	20,409,790.00
Гэрээт ажилчдын цалин	3,841,306.00	3,930,465.00
Унаа, хоолны хөнгөлөлт	18,380,200.00	17,309,600.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	21,263,319.00	21,262,967.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,423,860.00	17,534,237.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,570,509.00	13,728,702.00

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,549,674.00	1,568,294.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,919,731.00	1,864,367.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	383,946.00	372,874.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,839,459.00	3,728,730.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,614,437,559.54	710,288,473.87
Бараа үйлчилгээний урсгал зардал	912,976,932.54	508,971,647.60
Тогтмол зардал	3,823,379.00	5,620,426.40
Гэрэл цахилгаан	3,823,379.00	5,620,426.40
Бусад бараа үйлчилгээний зардал	909,153,553.54	503,351,221.20
Бичиг хэргийн зардал	8,782,698.00	11,239,173.00
Тээвэр, шатахуун	18,435,524.00	16,407,211.00
Шуудан, харилцаа холбоо	9,901,591.25	8,099,935.10
Дотоод албан томилолт	3,534,500.00	2,367,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	186,000.00	176,620.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	849,000.00	1,000,000.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	-	1,083,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	7,490,477.29	8,570,662.54
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	405,602,550.00	3,944,800.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	405,602,550.00	3,944,800.00
Урсгал засвар	166,876,678.23	130,932,773.54
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	204,165,647.77	318,885,930.02
Газрын төлбөр	-	644,116.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	701,460,627.00	201,316,826.27
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	58,958,678.00	4,447,070.27
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	58,958,678.00	4,447,070.27
Төсвийн хуваарилагдаагүй зардал	346,358,921.00	196,869,756.00
Бусад төсөл арга хэмжээ	346,358,921.00	196,869,756.00
ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН	150,845,647.84	30,122,165.24
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	150,845,647.84	30,122,165.24
Төвлөрүүлэх шилжүүлэг	150,845,647.84	30,122,165.24
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	1,965,000.00	1,840,065.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	1,965,000.00	1,840,065.00
Мөнгөн хэлбэрээр	1,965,000.00	1,840,065.00
Нэг удаагийн тэтгэмж	1,965,000.00	1,840,065.00
БУСАД ЗАРДАЛ	12,479,996.67	29,312,133.19
Бусдийн өмчийг ашигласаны зардал/түрээсийн зардал	12,479,996.67	29,312,133.19
Байрны түрээс	12,479,996.67	29,312,133.19
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,094,757,702.05	973,190,392.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	136,849,829.38	321,958,227.97
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	136,849,829.38	321,958,227.97

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,129,660,897.00	1,559,973,700.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	2,129,660,897.00	1,559,973,700.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	1,959,141,065.00	1,120,956,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	845,344,000.00	435,694,100.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	19,980,000.00	23,262,000.00
Хөрөнгийн	1,093,817,065.00	662,000,000.00
Төсөвт байгууллагаас	-	439,017,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	439,017,600.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	521,279,633.52	185,273,520.27
Бараа, үйлчилгээний борлуулалт	521,279,633.52	185,273,520.27
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	521,279,633.52	185,273,520.27
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	521,279,633.52	180,826,450.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	4,447,070.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,650,940,530.52	1,745,247,220.27
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	202,978,623.00	201,627,556.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	182,178,611.00	180,344,250.00
Үндсэн цалин	132,698,387.00	138,998,557.00
Бусад нэмэгдлүүд	25,959,054.00	20,507,557.00
Бусад нэмэгдэл	25,959,054.00	20,507,557.00
Гэрээт ажилчдын цалин	5,140,970.00	3,805,336.00
Унаа, хоолны хөнгөлөлт	18,380,200.00	17,032,800.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	20,800,012.00	21,283,306.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,615,866.00	17,498,641.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,809,066.00	13,696,100.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,522,700.00	1,565,300.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,903,400.00	1,864,367.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	380,700.00	372,874.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,184,146.00	3,784,665.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,194,695,527.46	806,958,300.85
Бараа үйлчилгээний урсгал зардал	636,267,849.46	164,981,240.58
Тогтмол зардал	3,823,379.00	5,620,426.40
Гэрэл цахилгаан	3,823,379.00	5,620,426.40
Бусад бараа үйлчилгээний зардал	632,444,470.46	159,360,814.18
Бичиг хэргийн зардал	8,822,183.00	10,615,938.00

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тээвэр, шатахуун	17,485,840.00	16,319,295.00
Шуудан, харилцаа холбоо	9,901,591.25	8,274,935.10
Дотоод албан томилолт	3,534,500.00	2,367,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	200,000.00	176,620.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	849,000.00	1,000,000.00
Жижиг эд хогшил худалдан авах	485,198.00	1,455,054.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	-	1,455,054.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	1,485,000.00	2,200,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	6,927,004.98	8,422,162.54
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	405,723,550.00	3,944,800.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	405,723,550.00	3,944,800.00
Урсгал засвар	111,702,452.23	103,940,893.54
Газрын төлбөр	-	644,116.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	558,427,678.00	641,977,060.27
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	59,013,678.00	443,464,670.27
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	-	439,017,600.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	59,013,678.00	4,447,070.27
Төсвийн хуваарилагдаагүй зардал	346,358,921.00	198,512,390.00
Бусад төсөл арга хэмжээ	346,358,921.00	198,512,390.00
ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН	150,845,647.84	30,122,165.24
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	150,845,647.84	30,122,165.24
Төвлөрүүлэх шилжүүлэг	150,845,647.84	30,122,165.24
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	7,755,379.00	1,840,065.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	7,755,379.00	1,840,065.00
Мөнгөн хэлбэрээр	7,755,379.00	1,840,065.00
Нэг удаагийн тэтгэмж	1,945,000.00	1,840,065.00
БУСАД ЗАРДАЛ	12,479,996.67	29,312,133.19
Бусдийн өмчийг ашигласаны зардал/түрээсийн зардал	12,479,996.67	29,312,133.19
Байрны түрээс	12,479,996.67	29,312,133.19
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	2,682,552,238.97	1,069,860,220.28
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(31,611,708.45)	675,386,999.99
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	180,934,014.00	667,288,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	180,934,014.00	667,288,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(180,934,014.00)	(667,288,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(212,545,722.45)	8,098,999.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	212,546,722.46	1,000.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,000.01	8,100,000.00

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	924,598,017.41	-	(25,429,644.43)	899,168,372.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,432,600.00)	(3,432,600.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			(28,862,244.43)	(28,862,244.43)
Тайлант үеийн үр дүн			321,958,227.97	321,958,227.97
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	924,598,017.41	-	293,095,983.54	1,217,694,000.95

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү +/-илүү, - дутуу/	Гүйцэтгэлийн хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	874,711,700.00	850,166,594.77	-24,545,105.23	97.2
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	874,711,700.00	850,166,594.77	-24,545,105.23	97.2
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	874,711,700.00	850,166,594.77	-24,545,105.23	97.2
Бараа ажил үйлчилгээний зардал	874,711,700.00	850,166,594.77	-24,545,105.23	97.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	217,181,400.00	201,627,556.00	-15,553,844.00	92.8
Үндсэн цалин	171,919,500.00	159,506,114.00	-12,413,386.00	92.8
Гэрээт ажлын цалин	5,628,000.00	3,805,336.00	-1,822,664.00	67.6
Хоол унааны хөнгөлөлт	18,111,400.00	17,032,800.00	-1,078,600.00	94.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,522,500.00	21,283,306.00	-239,194.00	98.9
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,609,300.00	17,498,641.00	-110,659.00	99.4
Тэтгэврийн даатгал	13,696,100.00	13,696,100.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	1,565,300.00	1,565,300.00	0.00	100.0
ҮОМШ өвчний даатгал	1,956,600.00	1,864,367.00	-92,233.00	95.3
Ажилгүйдлын даатгал	391,300.00	372,874.00	-18,426.00	95.3
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	3,913,200.00	3,784,665.00	-128,535.00	96.7
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	657,530,300.00	648,539,038.77	-8,991,261.23	98.6
Гэрэл цахилгааны зардал	9,600,000.00	5,620,426.40	-3,979,573.60	58.5
Бичиг хэргийн материал	10,616,000.00	10,615,938.00	-62.00	100.0
Тээвэр, шатахууны зардал	16,500,000.00	16,319,295.00	-180,705.00	98.9
Шуудан холбооны зардал	8,360,000.00	8,274,935.10	-85,064.90	99.0

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Дотоод томилолтын зардал	3,000,000.00	2,367,000.00	-633,000.00	78.9
Ном , хэвлэлийн зардал	200,000.00	176,620.00	-23,380.00	88.3
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	15,000,000.00	14,843,054.00	-156,946.00	99.0
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
Төлбөр, хураамж, жижиг татварууд	8,465,700.00	8,422,162.54	-43,537.46	99.5
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,972,000.00	3,944,800.00	-27,200.00	99.3
Урсгал засварын зардал	107,419,000.00	103,940,893.54	-3,478,106.46	96.8
Бусад зардал	860,000.00	644,116.00	-215,884.00	74.9
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	439,017,600.00	439,017,600.00	0.00	100.0
Байрны түрээсийн зардал	29,320,000.00	29,312,133.19	-7,866.81	100.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,840,065.00	-159,935.00	92.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,840,065.00	-159,935.00	92.0
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	874,711,700.00	850,165,594.76	-24,546,105.24	97.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,576,060.00	5,576,060.00	
Төсвөөс санхүүжих	435,694,100.00	405,571,934.76	-30,122,165.24	93.1
Төсвөөс санхүүжих /ҮШТҮ/	439,017,600.00	439,017,600.00	0.00	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		1,000.01	1,000.01	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00		
Ажиллагсад бүгд	1	1	-	0
Удирдах ажилтан	26	21	-5	-19.2
Гүйцэтгэх ажилтан	2	2	-	0
Үйлчлэх ажилтан	24	19	-5	-20.8